



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/458

Улаанбаатар хот

“Түшээ” сууц өмчлөгчдийн холбооны  
бүртгэлээс 34 дүгээр байрыг хасаж шинээр  
гэрчилгээ олгох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, 29.2, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол дүүргийн 12 дугаар хорооны 20/3, 24, 25, 26, 28, 34 дүгээр байрны “Түшээ” сууц өмчлөгчдийн холбооноос 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдөр гаргасан хүсэлт, холбогдох материалыг үндэслэн 34 дүгээр байрыг тус холбооны бүртгэлээс хассугай.

2.Түшээ сууц өмчлөгчдийн холбооны гэрчилгээг 20/3, 24, 25, 26, 28 дугаар байраар бүртгэж, шинээр гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулсугай.

3.Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд зохих өөрчлөлтийг хийж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, Нийтийн аж ахуйн хэлтэст үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР